



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 339

Улаанбаатар хот

Г “Хувьцаат компанийн төлөөлөн 7
удирдах зөвлөлийн гишүүнийг сонгоход
кумулятив аргыг хэрэглэх тухай журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалт, Компанийн тухай хуулийн 77.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгоход кумулятив аргыг хэрэглэх тухай журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар/Б.Саруул/, олон нийгэд мэдээлэхийг Тамгын газарт үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮНИЙГ СОНГОХОД КУМУЛЯТИВ АРГЫГ
ХЭРЭГЛЭХ ТУХАЙ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэ журмаар хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгоход санал хураах кумулятив аргыг хэрэглэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Өмчийн төрөл, хэлбэр, үйл ажиллагааны онцлогоос үл шалтгаалан хувьцаат компанийн /цаашид “компани” гэх/ хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд нь энэхүү журмын дагуу төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/-ийн ердийн болон хараат бус гишүүнийг сонгоно.

1.3. “ТУЗ-ийн хараат бус гишүүн” гэж Компанийн тухай хуулийн 79.1-д заасан шаардлагыг хангасан этгээдийг хэлнэ.

1.4. “ТУЗ-ийн ердийн гишүүн” энэ журмын 1.3-т зааснаас бусад ТУЗ-ийн гишүүнийг хэлнэ.

ХОЁР. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН БОЛОН
ХАРААТ БУС ГИШҮҮНИЙГ СОНГОХ

2.1. Компанийн ТУЗ-ийн гишүүний тоо есөөс доошгүй байх бөгөөд компанийн дүрмээр ТУЗ-ийн гишүүний тоог тогтооно.

2.2. Компанийн ТУЗ-ийн нийт гишүүнд ердийн ба хараат бус гишүүдийн эзлэх хувийг Компанийн тухай хуулийн 75.4-т заасан хязгаарын хүрээнд компанийн дүрмээр тогтооно.

2.3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг сонгохдоо зөвхөн санал хураах кумулятив аргыг хэрэглэнэ.

2.4. Кумулятив аргыг хэрэглэхэд энгийн хувьцаа тус бүр сонгогдох ердийн болон хараат бус гишүүдийн нийт тоотой тэнцэх хэмжээний саналын эрхтэй байх бөгөөд хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувьцаанд ногдох энэ санал нь ТУЗ-д эзлэх ердийн болон хараат бус гишүүний эзлэх хувьд хуваагдана.

2.5. Энэ журмын 2.4-т заасан саналаа хувьцаа эзэмшигч нь ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд эзлэх хувьд хуваагдсан хэмжээнд бүгдийг нь нэг ТУЗ-ийн ердийн болон

хараат бус гишүүнд нэр дэвшигчид, эсхүл хэд хэдэн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй.

2.6. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг сонгох саналыг тоолохдоо тус бүрд нь тоолж, хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнээр тус тус сонгоно.

Жишээ нь: хувьцаа эзэмшигч А нь “Б” ХК-ийн 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Компанийн дүрмээр тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон. Хувьцаа эзэмшигч А-ийн эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй 100×9 гишүүн=900/ болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно.

2.7. Энэ журамд заасан аргачлалаар ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг сонгоогүй, эсхүл Компанийн тухай хуулийн 75.4-т заасан тооны хараат бус гишүүнийг төлөөлөн удирдах зөвлөлд сонгож чадаагүй тохиолдолд тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадваргүйд тооцогдоно.

--ooOoo--